



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/Р 16

Улаанбаатар хот


Журамд өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын 2.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хууль зүйн сайдын 2010 оны 172 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 3.3 "Улсын байцаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн эсэхийг шалган тогтоох комиссыг зөрчлийн онцлогоос шалтгаалан гадаадын иргэний асуудал эрхлэх төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар томилно", 3.4 "Комисс нь зөрчлийг шалган олонхийн саналаар дүгнэлт гаргах бөгөөд гадаадын иргэний асуудал эрхлэх төрийн захиргааны байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ", 3.5 "Ёс зүйн зөрчилд холбогдсон улсын байцаагч нь баримт материалтай танилцах, нэмэлт тайлбар гаргах, шаардлагатай гэж үзсэн баримтыг тодруулахыг шаардах эрхтэй" гэсэн хэсгүүдийг тус тус хассугай.

2. Энэ тушаалыг дагаж мөрдөхийг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дарга /Д.Болд/-д үүрэг болгосугай.

САЙД



Д.ДОРЛИГЖАВ